



ДУНДГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 10 сарын 06 өдөр

Дугаар 235

Мандалговь

Хөрөнгө данснаас хасах тухай

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 22 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасахад баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1 “б”, “в”, 3.2.6 “г” заалтуудыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:


1. Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 1’298’000 /нэг сая хоёр зуун ерэн найман мянга/ төгрөгийн анхны өртөгтэй 11 нэр төрлийн хөрөнгийг хавсралт 1-ийн дагуу актлан данснаас хасах, 13’844’500 /арван гурван сая найман зуун дөчин дөрвөн мянга таван зуу/ төгрөгийн анхны өртөгтэй элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнээ нөхсөн ажилчдын зуны сууцыг хавсралт 2-ын дагуу актлан худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө актлах ажлыг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохион байгуулж, актлагдсан болон дуудлага худалдаагаар худалдагдсан хөрөнгийг зохих хууль журмын дагуу данс бүртгэлээс хасахыг Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн дарга Л.Оюунбаярт даалгасугай.

3. Хөрөнгө худалдах үнийн доод хязгаарыг тус бүр 100’000 /нэг зуун мянга/ төгрөгөөр тогтоон нийтийн дуудлага худалдааг журмын дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн албаны дарга П.Очирбатад үүрэг болгосугай.

ДАРГА  С.БУДЖАВ

Аймгийн ИТХТ-ийн 2014 оны 10 сарын 06 өдрийн 235-р тогтоолын хавсралт 1



Актлах хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Тоо ширхэг	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	Ундааны машин	97.01.01	1	277'500	277'500	0
2	Чихрын машин	96.01.01	1	153'800	153'800	0
3	Тоос сорогч	83.01.01	1	59'700	59'700	0
4	Угаалгын машин	83.01.01	1	11'700	11'700	0
5	Бойлуур	07.01.01	1	156'900	177'700	39'200
6	Телевизын тавган антен	07.01.01	1	122'100	91'600	30'500
7	Гар утас	07.01.01	1	174'000	174'000	0
8	2 хүний бие засах газар	83.01.01	2	1'900	1'900	0
9	6 хүний бие засах газар	83.01.01	1	4'600	4'600	0
10	Тоос сорогч	83.01.01	1	141'700	106'300	35'400
11	Угаалгын машин	83.01.01	1	194'100	108'800	85'300
Нийт дүн			12	1'298'000	1'107'600	190'400

АЙМГИЙН ИТХТ-ийн 2014 оны 10 сарын
06 өдрийн 235 р тогтоолын хавсралт 2

Дуудлага худалдаагаар худалдах хөрөнгө

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Тоо ширхэг	Балансын үнэ	Үлдэгдэл өртөг	Худалдах үнийн доод хязгаар /1 бүрийн үнэ/	Худалдах үнийн доод хязгаар /Нийт үнэ/
1	Ажилчдын зуны сууц	83.01.01	4	13'844'500	0	100'000	400'000
	Дүн			13'844'500	0	100'000	400'000